

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Захиргааны хэлтэс	
1	<p>Захиргааны хэлтсийн дарга</p> <p>1. Байгууллагын хэмжээнд мөрдөх бодлогын баримт бичиг, хөтөлбөр, дүрэм, журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлэх; 2. Салбарын хууль тотоомж, УИХ, ЗГ, НИТХ-ын тогтоол, НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр, НЭЗЗ, НЗД-ын шийдвэрүүдийг хэрэгжүүлэх; 3. Төрийн байгууллагын санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангуулах, Төсвийн тухай хууль, НББ-ын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон холбогдох журмууд, УСНББ-ийн стандартыг хэрэгжүүлэх; 4. Төрийн захиргааны болон хэлтсийн албан хаагчдыг шуурхай удирдлагаар хангаж ажиллах;</p>
2	<p>Эрх зүй, дотоод аудит, хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн</p> <p>1. Байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд хяналт шинжилгээ, аудит хийх хууль, дүрэм, журмыг сурталчлан таниулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах; 2. Байгууллагын албан хаагч нарын ажлын байрны чиг үүрэг, төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөмж гаргах, байгууллагаас гарч буй эрх зүйн баримт бичгийг боловсруулах, үндэслэлийг хянах; 3. Харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, арга зүйгээр хангах; 4. Хууль зүйн зөвлөгөө, гэрээний хэрэгжилт, журмын төсөл боловсруулах, санал өгөх ажлыг хэрэгжүүлэх; 5. Ажлын хариуцлага, бүтээмжийг сайжруулах; 6. Газрын даргын үр дүнгийн гэрээг боловсруулан батлуулах, биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж хүргүүлэх;</p>
3	<p>Хүний нөөц төлөвлөлт, тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн</p> <p>1. Хүний нөөцийн асуудал, хууль тогтоомж, байгууллагад хэрэгжиж буй дүрэм, журам, хөтөлбөр, шийдвэртэй танилцаж албан хаагчдад танилцуулах; 2. Хүний нөөцийн судалгаа, мэдээллийн санг бүрдүүлэх; 3. Байгууллагын хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх ; 4. Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах асуудлыг судалж, албан хаагчдад танилцуулах, Авилгаас урьдчилан сэргийлэх, ХАСХОМ-н мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, тайлагнах; 5. Нийслэлийн Засаг даргын шуурхайн болон газрын даргын шуурхайн үүрэг даалгаварын биелэлтийг хангаж ажиллана; 6. Ажлын хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх;</p>
4	<p>Залуучуудын эрүүл мэнд, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн</p> <p>1. Залуучуудын нийгмийн хамгааллын чиглэлийн асуудлын нэгдсэн зохицуулалтыг хийх; 2. Залуучуудын нийгмийн хамгааллын чиглэлээр төрөөс хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн биелэлтийг</p>

		<p>нэгтгэн гаргах;</p> <p>3. Залуучуудад эрүүл зөв амьдралын хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах;</p> <p>4. Ажлын байрны хариуцлага, бүтээмжийг дээшлүүлэх.</p>
5	Архив, бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн	<p>1. Байгууллагын хэмжээнд үүсч хөтлөгдөж буй баримт бичигт стандартыг хэрэгжүүлж ажиллах;</p> <p>2. Байгууллагын архивын үйл ажиллагааг зааврын дагуу явуулах;</p> <p>3. Байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх хугацаанд хяналт тавих;</p> <p>4. Ажлын байрны хариуцлага, бүтээмж нэмэгдүүлэх;</p>
Бодлого зохицуулалтын хэлтэс		
6	Бодлого зохицуулалтын хэлтсийн дарга	<p>1. Залуучуудын чиглэлээр хууль тогтоомж, ЗГ, НИТХ, НЗД-ын мөрийн хөтөлбөр, НЭЗЗ, НЗД-ын шийдвэр гарсан захирамж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах;</p> <p>2. Хэлтсийн мэргэжилтнүүдийг удирдлага арга зүйгээр хангах;</p> <p>3. Залуучуудын орчин нөхцөл үйлчилгээг сайжруулах чиглэлээр шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх;</p> <p>4. Залуучуудын чиглэлээр ажиллагсдын түншлэл, хамтын ажиллагаа, нөлөөллийг бэхжүүлэх ажлыг удирдан чиглүүлэх;</p> <p>5. Ажлын хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх;</p>
7	Залуучуудын хөгжлийн хөтөлбөр, үйл ажиллагааны зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	<p>1. Залуучуудын насны онцлог, хэрэгцээг судалж хөгжлийн хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулах;</p> <p>2. Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг санаачлан, талуудтай хамтран хэрэгжүүлэх;</p> <p>3. Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн санаачлагыг байгууллага, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх;</p> <p>4. Хэлтсийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн зохион байгуулагдахад зохицуулалтаар хангах;</p> <p>5. Ажлын хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх;</p>
8	Түншлэл хамтын ажиллагаа, хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн	<p>1. Залуучуудын асуудлаарх түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх;</p> <p>2. Залуучуудын нийгмийн хамгааллын асуудлаарх нэгдсэн зохицуулалтыг хийх;</p> <p>3. Залуучуудын хөдөлмөр эрхлэх боломжийг дээшлүүлэх, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлэх, бүтээмж өндөртэй ажлын байр бий болгох, залуучуудыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, хөрвөх чадвартай боловсон хүчин болгон хөгжүүлэх;</p> <p>4. Ажлын байрны хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх.</p>
9	Залуучуудын амралт, чөлөөт цаг,	<p>1. Залуучуудын амралт, чөлөөт цагийн</p>

	орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	<p>үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах;</p> <p>2. Залуучуудад ээлтэй орчин бүрдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;</p> <p>3. Залуучуудад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, хяналт үнэлгээ хийх;</p> <p>4. Ажлын байрны хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх.</p>
10	Ухуулга сурталчилгаа, эерэг нөлөөлөл хариуцсан мэргэжилтэн	<p>1. Залуучуудын чиглэлээр байгууллагын хэмжээнд явуулж буй үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр олон нийтэд сурталчлах;</p> <p>2. Сурталчилгаа, нөлөөллийн чиглэлээр холбогдох ажилтнуудыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах;</p> <p>3. Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг дүгнэн, тайлагнах ;</p> <p>4. Ажлын байрны хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх;</p>
11	Цахим нийгмийн харилцаа, мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн	<p>1. Мэдээллийн технологийн програмуудыг ашиглалт, үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж, холбогдох журмыг хэрэгжүүлэх;</p> <p>2. Залуучуудын хөгжлийн мэдээллийн санг баяжуулж, ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;</p> <p>3. Байгууллагын цахим мэдээллийн сувгуудын мэдээллийн баяжилт, хяналтыг хангаж, бусад холбогдох фэйсбүүк, сайтад мэдээлэл оруулах;</p> <p>4. Байгууллагын техник технологийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах;</p> <p>5. Ажлын хариуцлага бүтээмжийг нэмэгдүүлэх;</p>